



МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж 11, Засгийн газрын XI байр,
Утас: 26 09 75, Факс: (976-11) 32 69 75,
E-mail: gecm@gec.gov.mn, http://www.gec.gov.mn

2021.08.27 № 1/332

танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН, НИЙСЛЭЛИЙН
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
СОНГУУЛИЙН ХОРООДОД

Чиглэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын 18, 28 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах явцад коронавируст халдвар /Covid-19/-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлах, сахиулах шаардлага үүсч байна.


Улсын онцгой комиссоос 2021 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 1318 дугаар албан бичгээр тус Хороонд ирүүлсэн чиглэлийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар буюу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 152 дугаар тогтоолоор батлагдсан “Түр журам”-ыг 18, 28 дугаар тойрогт явагдах нөхөн сонгуулийн явцад мөрдлөг болгон ажиллана.

Иймд холбогдох мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийн дагуу коронавируст халдвар /Covid-19/-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмжийг чанд мөрдөх, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 152 дугаар тогтоолоор батлагдсан “Түр журам”-ын хэрэгжилтийг хангах ажлыг онцгой байдлын болон эрүүл мэндийн байгууллага, бусад холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж ажиллана уу.

Хавсралтаар: Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 152 дугаар тогтоолоор батлагдсан түр журмыг хүргүүлэв.

Хүндэтгэсэн,

ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН